

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан шүүх эрх мэдэл хараат бус, бие даасан байж, чухамхүү нийгмийн шударга ёсны дархлаа байх үндэс нь Шүүхийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг хуульчилсан материаллаг хуулиас гадна шүүх хэргийг үнэн зөв, чигч шударгаар шийдвэрлэх дэс дараа, горим, зарчмыг тогтоодог процессын хуулиас хамаардаг. Тийм учраас шүүхийн процесс дахь шударга ёсны зарчмыг хэр тогтоохоос бүхэлдээ шүүх эрх мэдлийн нэр хүндтэй оршихуй хамаарна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “...гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.” гэх гэм буруугийн зарчмыг хуульчилсан. Шүүхийн шийдвэр эцэслэж гарах хүртэл хэн ч хэнийг ч гэмт хэрэгтнээр “зарлахгүй” гэх энэхүү зарчим нь гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, мөрдөн шалгах, гэм буруугийн асуудлыг шүүхээр хэлэлцэх бүхий л процесст эхнээс нь дуустал үйлчлэх учиртай. Тэр ч утгаараа Эрүүгийн процессын үндсэн “оролцогч”-ид болох мөрдөгч, прокурор, шүүгч нарт яллах ба цагаатгах нотлох баримтыг бүгдийг тэгш цуглуулах, үнэлэх, аль нэг талыг хэт баримталж, давуу байдлыг олгох буюу гаргахгүйгээр шүүх хуралдаанд талууд мэтгэлцэхийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчим болгож хуульчилсан. Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйл буюу “Гэм буруугүйд тооцох” зарчмыг хуульчлахдаа Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “гэм буруугийн зарчим”-г илүү тодорхой, дэлгэрүүлж томъёолсныг дурьдвал:

“1.15 дугаар зүйл. Гэм буруугүйд тооцох

1. Шүүхийн **шийтгэх тогтоол гарах хүртэл** хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй.

2. Эрүүгийн хэрэгт хамааралтай **бүхий л нотлох баримтыг шалгасан боловч** сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн **гэм буруутай эсэхэд**, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд **эргэлзээ гарвал** түүнийг сэжигтэн, яллагдагч, **шүүгдэгч**, ялтанд **ашигтайгаар шийдвэрлэнэ.**” гэжээ.” Нотлох баримт гэдгийг мөн хуулийн 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлохдоо: “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, **энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.**”, мөн зүйлийн 9

дэх хэсэгт: “Хавтаст хэрэгт авагдаагүй нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.” гэжээ. Өөрөөр хэлбэл, шүүх нь шүүхэд хуулийн дагуу цугларсан нотлох баримтын хэмжээнд үндэслэж хэрэг маргааныг шийдвэрлэхийг нэн тодорхой хэлж өгсөн бөгөөд сураг ажигаар, олон нийтийн сэтгэл зүйгээр эсхүл танил тал, аливаа албан тушаалтан, хувь хүний нөлөөллөөр шүүхэд ирээгүй баримт мэдээлэл, сэжиг таамаг, сэтгэл хөдлөлд үндэслэж шийдвэрээ хэрхэвч гаргаж болохгүйг хэлж өгсөн байна. Үүнийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цааш дэлгэрүүлэн, дахин нэн тодорхой байдлаар хуульчилсан асуудал нь шүүх дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах хэмжээ хязгаарыг заасан 34.14 дүгээр зүйл, мөн шүүхийн шийдвэр чухамхүү ямар хэлбэр, бүтэцтэй байхыг хэлж өгсөн 36.2 дугаар зүйлээр илэрнэ. Тодруулбал, уг хуулийн 34.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн **шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд явагдана.**”, 36.2 дугаар зүйлд:

“36.2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийн хэлбэр, бүтэц

1.Монгол Улсын нэрийн өмнөөс гаргах шүүхийн шийдвэр нь **шийтгэх, эсхүл цагаатгах хэлбэртэй байна.**

4.Шүүх хуралдааны үед шүүгдэгч **гэм буруутай болох нь нотлогдсон бол шүүх шийтгэх тогтоол** гаргана.

5.Шүүгдэгчийн холбогдсон үйлдэл, эс үйлдэхүй нь **гэмт хэргийн шинжгүй, эсхүл шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй бол шүүх цагаатгах тогтоол** гаргана.” гэж тус тус заажээ.

Дээр дурьдсан Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалд үндэслэн гарсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарчмуудыг бүхэлд нь дүгнэвэл “Нотол, нотолж чадахгүй бол цагаатга” гэх зарчмыг манай улс үндэсний хууль тогтоомждоо нутагшуулсаар ирсэн байна. Үүнийг нөгөө талаар “Нэг гэмгүй хүнийг хилсээр ялласан дорвол зуун гэмт хэрэгтэнг сулла” гэдэг хэлц үгээр ч илэрхийлсэн нь байдаг. Товчдоо, гэмт хэрэгтэнг олж илрүүлэх, гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, түүнд ял шийтгэл ногдуулах нь төрийн үндсэн чиг үүрэг, хийх ажил бөгөөд хэрэгтнээр өөрөөр нь хэргийг нь нотлуулах, тулгах, хилс ял шийтгэхээс төр үргэлж зайлсхийж, тийм хэлмэгдүүлэлтийг ямар ч үед гаргаж болохгүй, хуулийнхан тийнхүү хуулиас гадуур ажиллаж хэн нэгнийг хэлмэгдүүлэхийг хэзээ ч, хэрхэвч зөвтгөж болохгүй гэх суурь зарчим, хүний язгуур эрхийг хамгаалахад дээр дурьдсан Үндсэн хууль, бусад хуулийн амин сүнс чиглэж байна. Тухайлбал, хүнийг өмгөөлөгчгүйгээр байцаасан бол шүүх тухайн хүний үндсэн эрхийг зөрчиж цуглуулсан буюу хуулийн дагуу л цуглуулаагүй бол бүхий л нотлох баримтыг үнэлэхээс татгалзаж, тухайн этгээдийг цагаатгах зарчим энд үйлчилнэ гэсэн үг. Энэ нь магадгүй олон нийтийн хувьд гэм буруутай хүнийг шүүх цагаатгачихлаа гэдэг шүүмжлэл, сэтгэл зүйг үүсгэж болох ч гэсэн үүнээс ч илүүтэй төр, шүүх, хуулийнхан хэзээ ч хүний үндсэн эрхийг зөрчиж, хуулийг зөрчих байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хийж болохгүй шүү гэдгийг хатуу сануулж, тэднийг хариуцлагажуулж, жишиг болгож буй зорилго, зарчмыг илүү том авч үзсэн үзэл санаа ажээ.

Өөрөөр хэлбэл, шүүх нэг ч хүнд ял завшуулахгүй байх зарчим ба нэг ч хүнийг хилсээр шийтгэхгүй байх зарчмыг дэнслэхдээ юун түрүүн хоёр дахь зарчмыг иш үндэс болгож шийдвэрээ гаргана гэдгийг “эргэлзээ гарвал шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ” гэх хуулийн заалт нотолж байна. Гэтэл дээр дурьдсан Үндсэн хууль, хуулийн заалт, зарчимтай зөрчилдсөн, үгүйсгэсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шүүхээс шүүхийн гэм буруугийн хуралдааны үе шатанд(шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр бус) хэргийг прокурорт буцаах хуулийн зохицуулалт үйлчилж байна. Нэг хуульд өөр хоорондоо зөрчилдсөн бөгөөд шүүхээс “нотолж чадахгүй бол цагаатгах” биш “яаж ийгээд нотлоод ир” гэсэн агуулгатай гуравдахь-“буцаах” гэдэг шийдвэр гаргах зохицуулалтыг бий болгосон байна.

2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн гэм буруугийн хуралдаанаас прокурорт буцаах зохицуулалтыг авч хаясан байсан боловч 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухайн хуулийн, тухайн зүйл анги, зарчмыг хөндөөгүй шийдвэрийг УИХ иш үндэс болгож тийнхүү гэм буруугийн шүүх хуралдаанаас прокурорт буцаах заалтыг сэргээн оруулсан байна. Гэм буруугийн шүүх хуралдаанаас хэргийг прокурорт буцаах нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс прокурорт буцаахаас зарчмын өөр агуулга, үр дагавартай. Үүнд:

Нэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй." гэж заасан. Хэргийг буруу тусгаарласан, мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу хийгдсэн ба шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн алдаа гарсан тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, мөн хуулийн 33.3 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд шүүгч хэргийг прокурорт буцаах боломжтой. Шинэчилсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн чухамхүү нэг гол үзэл баримтлал нь шүүхийн хэлэлцүүлгийн үе шатыг хоёр хувааж шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, гэм буруугийн шүүх хуралдаан гэж зааглаж салгасны мөн чанар, зорилго, агуулга дээр дурьдсан хууль зөрчигдөж, алдаа эндэгдэл гарвал шүүхээс хэргийг прокурорт буцаах замаар, алдааг залруулах тусгайлсан үе шатыг бий болгосон явдал юм. Гэтэл гэм буруугийн шүүх хуралдаанаас хэргийг буцаахаар болсон нь хэрэг дээрээ тийнхүү хоёр үе шатанд хуваахын утга учрыг алдагдуулсан хэрэг болов.

Хоёр. Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанаар шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг тогтоосны дараа, шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орохын өмнө буюу шүүхийн шатанд тухайн шүүх хуралдаанд яллах дүгнэлт үйлдэж орсон прокурорын "хэргийг прокурорт буцаах шаардлагатай гэж үзсэн" тайлбаргүй саналыг үндэслэж хэргийг прокурорт буцаах нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан шүүх эрх мэдлийн агуулга, эрүүгийн эрх зүйн суурь болсон гэм буруугийн зарчимд нийцэхгүй бөгөөд шүүгч, прокурорт авилга өгөх, шүүхээс хэргийг үнэн бодитойгоор шийдвэрлэх боломжийг

хязгаарлах нөхцлийг бүрдүүлжээ. Нэгэнтээ хэрэг нотлогдсон гэж үзэж шүүхэд шилжүүлсэн прокурорын яллах дүгнэлтийг шүүх үндэслэлтэй байна гэж үзэж, шүүгдэгчийг гэм буруутай гэж шийдвэрлэсний дараа прокурор юу нь тодорхойгүй үндэслэлээр хэргийг буцааж шүүхээс татаж аван мөрдөн байцаалт руу буцаах нь шүүхийн “гэм буруутай” гэж үзсэн эцсийн шийдвэрийг үгүйсгэсэн, прокурор нь шүүхийнхээ дээр гарсан, шүүгдэгчийн тухайтад шүүх дээр өөрийгөө гэм буруугүй гэж бүхий л үе шатанд мэтгэлцчихээд үнэнд гүйцэгдэн гэм буруутай гэж шүүх үзэнгүүт ял шийтгэгдэхгүй байхын тулд прокурорт нөлөөлөх замаар хэргээ буцаалгаж хугацаа хожих, улмаар ял завших, авлига болон бусад хууль бус нөлөөллийг үзүүлэх сэдэл, хийдлийг бий болгосон байна.

Гурав. Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг прокурорт буцаах эрх хэмжээ нь шүүгдэгчийн гэм бурууг шүүхээр дахин хэлэлцүүлэхээс өөр аргагүй болгож, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн “*double jeopardy*” буюу шүүгдэгчийн гэм бурууг нэг л удаа шүүхээр эцэслэн шийдвэрлэх зарчмыг ноцтой зөрчиж байна. Мөн шүүхийн бие даасан байдлын зарчим, шүүгч, прокурорын гаднын нөлөөнд үл автах зарчим, гэм буруугийн зарчмыг гажуудуулахаас гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, зардлыг нэмэгдүүлж, оролцогчдыг чирэгдүүлэх нөхцөл байдлыг бий болгож байна. Түүнчлэн хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүхэд эрүүгийн хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар чиглэл өгөх, доод шатны шүүхийн шударгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, шүүгч, прокурор нар авилга авах, хэлэлцэн тохиролцож хугацаа авах замаар гэм буруутай этгээдийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр ял завшуулах боломж олгосноос гадна Эрүүгийн хуульд заасан ял шийтгэл гарцаагүй байх зарчим хэрэгжихгүй байх нөхцөл үүсгэжээ.

Дөрөв. Шүүхийн практикт шүүх, прокурорын байгууллага эрх мэдэл, эд хөрөнгө, албан тушаалтай хүмүүс, улс төрд нөлөө бүхий этгээдийн дарамт шахалтад орох, авилгын сүлжээ бий болгох, хэргийг сунжруулсаар хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр Эрүүгийн хуульд заасан хүндэвтэр болон хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завшуулах үндсийг бий болгож байна. Ялангуяа 1-5 жилийн хөөн хэлэлцэх хугацаатай гэмт хэргүүдийн тухайтад мөрдөн байцаалтын шатанд хэргийг удаанаар “барих”, яг хөөн хэлэлцэх хугацаа дуусах дөхөнгүүт шүүхэд хэргийг шилжүүлэх, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгонгуут энэ нь шүүхийн хийсэн алдаа, завхрал мэт сэтгэл зүйг олон нийтийн дунд үүсгэх гэх мэт хуйвалдааны сүлжээ бий болсон нь сүүлийн үед олны анхааралд байсан олон гэмт хэргүүдийг шийдвэрлэж буй практикаас харагдаж байна. Нөгөө талаар мөрдөгч, прокурор нь хаашдаа шүүхээс буцаадаг заалт байгаа юм чинь гэдгээр дутуу шалгасан, хэргийн бодит байдал бүх талын нотлох баримтаар нотлогдож чадаагүй, “дутуу боосон” хэргийг шүүхээс чиглэл авчихья гэдэг байдлаар шүүхэд шилжүүлж, улмаар тодорхой чиглэл авч буцаалган тэр чиглэлийнхээ хүрээнд дахин ажиллагаа хийдэг хариуцлагагүй практик хөгжих үндэс болжээ. Прокурор, мөрдөгчийн ажлаа дутуу хийсэн байдлыг өөгшүүлдэг, тэдний алдаа болгоныг засах үүрэг шүүхэд байх учиргүй. Шүүх нь чиглэл, даалгавар өгдөг этгээд биш юм. Шүүх дээр бүрэн нотлогдлоо, бүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж дууслаа гэж үзэгдсэн хэрэг л ирж,

эцэслэн шийдвэрлэгддэг байх нь шударга ёс мөн. Нөгөө талаар тийнхүү олон дахин дутуу шалгасан хэргийг буцаах нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх тухай Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн хуулийн үндсэн зорилго, зарчимтай огт нийцэхгүй байна.

Тав. Яллагдагч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.3 дугаар зүйлд заасан "ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх", мөн хуулийн 17 дугаар бүлэгт заасан журмын дагуу гэм буруугаа хүлээн зөвшөөрч, өөрийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн шийдвэр гаргуулах зэрэг эрхтэй. Харин шүүх хуралдаанаар нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэж зүйлчлэлийг хүндрүүлэх эсхүл шинээр ял сонсгохын тулд шүүхийн шатанд хэргийг прокурорт буцаах ерөнхий зохицуулалтыг хэрэглэж байгаа нь яллагдагч дээрх эрхээ бодитойгоор эдлэх боломжийг хязгаарлаж байна. Иймд Үндсэн хуулиар баталгаажсан иргэний үндсэн эрх, суурь зарчмыг гажуудуулж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.14 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу шүүх хуралдаанаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдалд үндэслэн зүйлчлэлийг хүндрүүлэх, эсхүл мөрдөн байцаалтын шатанд нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журмыг ноцтой зөрчсөн тохиолдлуудыг шийдвэрлэж, шүүхээс хууль ёсны ба үндэслэл бүхий шийдвэр гаргах боломж олгох зорилгоор НЭГ УДАА 30 ХОНОГООР хойшлуулах нэн тодорхой зохицуулалтыг шинээр бий болгож болох юм гэж үзлээ.

Зургаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13 дахь заалтын "нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар энэ хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол", мөн зүйлийн 6.14 дэх заалтын "хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдол" зэргийг мөн хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэхгүй орхиж, анхан шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэнэ гэж заасан нь уг гомдол, хүсэлтийг бодитойгоор шийдвэрлэх боломж бүрдүүлсэн зохицуулалт болж чадахгүй байна.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 10 дугаар зүйлд "Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй" гэж, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй..." гэж тус тус заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид Монгол Улс 2005 онд нэгдэж орсон бөгөөд тус конвенцийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүхийн хараат бус байдал, авилгын эсрэг тэмцэл дэх түүний шийдвэрлэх үүргийг санан, оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр

шүүхийн байгууллагад ажиллагсдын шударга байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн дунд авилгад автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна." гэж заажээ.

Олон улсын сайн туршлагаас авч үзвэл гадаад улс, орнууд эдгээр зарчмыг хамгаалсан, шүүхийн байгууллагыг авлигад автах эрсдэлээс урьдчилан сэргийлсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгожээ. Тухайлбал, Франц улсын Эрүүгийн процесс ажиллагааны хуульд шүүхийн өмнөх шатанд мөрдөн байцаах ажиллагаа дутуу явагдсан, түүнчлэн хэргийг нэг мөр шийдвэрлэхэд тодорхой үйл баримтыг тогтоох гарцаагүй шаардлагатай гэж үзвэл даргалагч шүүгч захирамж гаргаж, мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар заасан байна.

Харин Латви улсын 2005 онд баталсан Эрүүгийн процесс ажиллагааны хуульд шилжүүлсэн хэргийг нэмж шалгуулахаар шүүхийн өмнөх шатанд буюу прокурорт буцаах зохицуулалт байхгүй байна. Эрүүгийн процесс ажиллагааны хуулийн 461 дүгээр зүйлд заасны дагуу шүүх хуралдаанд оролцсон прокурор ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж өөрчлөх шаардлагатай бол нарийвчилсан журам хэрэглэдэг аж. Тодруулбал, хэргийн бодит байдал өөрчлөгдсөнөөр зүйлчлэлийг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж өөрчлөх бол шүүх, яллагдагч, түүний өмгөөлөгчийн шаардсанаар прокурор нь шинээр ял сонсгох тухай бичгээр мэдэгдэж, шүүх хуралдааныг нэг сараас илүүгүй хугацаагаар хойшлуулдаг байна. Шүүх хуралдааны явцад хэргийн өөр нөхцөл байдал тогтоогдож, зүйлчлэлийг хүндрүүлэн өөрчлөх шаардлагатай бол прокурорын хүсэлтээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэмж явуулахаар шүүх хуралдааныг мөн адил нэг сараас илүүгүй хугацаагаар хойшлуулна.

Иймд хэргийн бодит байдлыг тогтоох, оролцогчдын эрхийг хангах, хэргийг буруу тусгаарласан, мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн алдааг засах, дутуу хийсэн мөрдөн шалгах ажиллагааг нөхөж хийх зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, мөн хуулийн 33.3 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд хэргийг прокурорт буцаах зохицуулалтыг хэвээр үлдээж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.7 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, 39.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 40.8 дугаар заалтын дагуу шүүхийн шатанд болон давж заалдах, хяналтын шатны шүүхээс хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах зохицуулалтыг хүчингүй болгох хуулийн төслийг санаачлан боловсруулах шаардлагатай гэж хууль тогтоогчийн хувьд үзэж байна.

Хэрэв шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэх шаардлагатай болсон, эсхүл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан болон нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар талуудын гаргасан гомдлыг шийдвэрлэх нөхцөлд шүүх хэрэг хянан хэлэлцэхийг нэг удаа 30 хүртэл хоногоор хойшлуулж, шаардлагатай ажиллагаа явуулахыг прокурорт даалгах нарийвчилсан зохицуулалтыг шинээр нэмэх нь зүйтэй гэж үзлээ. Ийнхүү прокурор шүүхээс тогтоосон хугацаанд эдгээр ажиллагааг явуулснаар хэргийг

шүүх хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлэгдэхгүй өнгөрдөг байсан асуудлыг бодитойгоор хэлэлцэх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь шүүх, прокурорын байгууллагад улс төрд нөлөө бүхий этгээдээс дарамт шахалт үзүүлэх, авилга өгөхөөс урьдчилан сэргийлэх бөгөөд Үндсэн хуулиар баталгаажсан шүүхийн бие даасан байдлын зарчим, прокурорын гаднын нөлөөнд үл автах зарчим, гэм буруугийн зарчим, дэлхий нийтийн хүлээн зөвшөөрсөн шүүгдэгчийн гэм бурууг нэг л удаа шүүхээр эцэслэн шийдвэрлэх зарчмыг ноцтой зөрчиж, гэм буруутай этгээдэд ял завших боломж олгож буй хуулийн хийдлийг залруулах ач холбогдолтой байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.1 дэх заалтад “тухай асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан бол хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа хамаарахгүй.” гэж заасан бөгөөд уг хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд зөвхөн хуулиар зохицуулахаар заасан харилцаа тул уг тандан судалгааг хийх шаардлагагүй юм.

Хоёр. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд бүрэн нийцэж, шүүх, прокурор, мөрдөх байгууллагын хараат бус байдлыг хангаж, гэм буруутай этгээдэд ял завших боломж үүсгэсэн хуулийн хийдэл арилж, хэргийн нөхцөл байдлыг тогтоох, оролцогчдийн эрхийг бодитойгоор хангах боломжийг бүрдүүлэх, шүүхээс хууль ёсны ба үндэслэл бүхий шийдвэр гарах нөхцөл бүрдэнэ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан төсөв, санхүүгийн ямар нэгэн зардал гарахгүй.

Гурав. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг сайжруулах зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байна.